



# БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

*2022 оны 1 дүгээр улирлын тайлан*

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР**

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын  
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

## Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт .....	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт .....	7
“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	7
“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт.....	7
“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт ..	7
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт .....	8
Статистик үзүүлэлтүүд .....	9
Харилцагчид, зээлдэгчид.....	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид .....	9
Тархалт .....	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгөн хөрөнгө.....	12
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	12
Факторингийн тооцооны авлага.....	13
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө .....	13
Зээл.....	13
Цахим зээл.....	16
Ногоон зээл .....	17
Бусад хөрөнгө .....	18
Эргэлтийн бус хөрөнгө .....	18
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт .....	19
Санхүүгийн эх үүсвэр .....	19
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг .....	20
Бусад эх үүсвэр .....	20
ББСБ-аас гаргасан өрийн бичиг .....	21
Төслийн зээлийн санхүүжилт.....	22
Бусад өр төлбөр .....	22
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	22
Бусад өмч, сангууд .....	23
Хуримтлагдсан ашиг .....	23
Хоёрдогч өглөг.....	24
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	27
Дүгнэлт .....	28
Актив, пассивын бүтэц.....	28
Ашигт ажиллагаа .....	29
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	29

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл .....	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/ .....	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа .....	5
Хүснэгт 5 Харилцагчдын мэдээлэл.....	9
Хүснэгт 6 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	9
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл .....	9
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт .....	10
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт .....	10
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/ .....	11
Хүснэгт 12 Активын интервал /тэрбум төгрөгөөр/ .....	11
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	12
Хүснэгт 14 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	12
Хүснэгт 15 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 16 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/ .....	13
Хүснэгт 17 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/ .....	13
Хүснэгт 18 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/.....	15
Хүснэгт 19 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/.....	15
Хүснэгт 20 Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	16
Хүснэгт 21 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/ .....	17
Хүснэгт 22 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/ .....	18
Хүснэгт 23 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/ .....	18
Хүснэгт 24 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/ .....	19
Хүснэгт 25 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/ .....	20
Хүснэгт 27 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/.....	20
Хүснэгт 28 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	20
Хүснэгт 30 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/.....	21
Хүснэгт 33 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 34 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 35 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 36 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/ .....	23
Хүснэгт 37 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/ .....	23
Хүснэгт 38 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/.....	24
Хүснэгт 40 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/.....	25
Хүснэгт 41 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/ .....	26
Хүснэгт 42 2022 оны I улирлын валют арилжааны сарын мэдээ /тэрбум төгрөгөөр/ .....	26
Хүснэгт 43 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/.....	27

## Зургийн жагсаалт

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/ .....	11
Зураг 2 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/ .....	12
Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/ .....	14
Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/ .....	14
Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангиллаар/ .....	15
Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/ .....	18
Зураг 8 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/ .....	19
Зураг 9 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/ .....	20
Зураг 10 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /сая төгрөгөөр/ .....	21
Зураг 11 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/ .....	21
Зураг 12 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/ .....	23
Зураг 13 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/ .....	25

## Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

## Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2022 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 529 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 ББСБ буюу 0.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 85 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2018-I	2019-I	2020-I	2021-I	2022-I
Шинээр олгосон	5	3	3	1	6
Хүчингүй	2	3	1	3	11
Түдгэлзүүлсэн	-	4	18	-	4
Сэргээсэн	1	4	1	5	5
<b>Нийт ББСБ</b>	<b>537</b>	<b>539</b>	<b>540</b>	<b>530</b>	<b>529</b>
Үүнээс: ХОН	76	77	75	76	85
Үүнээс: ГХО	28	27	28	30	28
Салбар	177	220	273	298	393
Төлөөлөгч	4	5	9	8	8

2022 оны I улиралд 6 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 11 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 4 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 5 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2022 оны I улирлын байдлаар 32 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2021.I	2022.I	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	2,089.1	2,972.8	42.3%
Банкны салбартай харьцуулахад хувиар	5.6%	7.4%	1.8%
Нийт өөрийн хөрөнгө	1,482.2	1,864.3	25.8%
Банкны салбартай харьцуулахад хувиар	47.0%	50.2%	3.2%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,027.3	1,164.6	13.4%
Банкны салбартай харьцуулахад хувиар	125.2%	75.2%	-50.0%
Нийт зээл	1,422.0	2,293.6	61.3%
Банкны салбартай харьцуулахад хувиар	7.8%	10.2%	2.4%
Нийт орлого	109.1	184.4	69.0%
Нийт зарлага	67.6	105.8	56.5%
Цэвэр ашиг	41.5	78.6	89.2%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 42.3 хувиар өсөж, банкны салбарын 7.4%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 75.2%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үеүүдтэй харьцуулахад 50 пунктээр буурсан дүн юм.

2022 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 42.3 хувиар буюу 883.7 тэрбум төгрөгөөр өсөж 3.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 98.1 хувийг цэвэр зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 56.8 хувийг өр төлбөрийн өсөлт, 43.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-уудын ашигт ажиллагаа огцом өсөлт үзүүлж өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 69.0 хувиар буюу 75.3 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 56.5 хувиар буюу 38.2 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 89.2 хувиар буюу 37.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2021-I	2022-I	тоо	хувь
	Нийт ББСБ-ын тоо	530	529	(1)	-0.2%
1	Зээл	492	492	-	0.0%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	331	321	(10)	-3.0%
2	Факторинг	35	41	6	17.1%
3	Төлбөрийн баталгаа гаргах	21	27	6	28.6%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	5	-	0.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	35	38	3	8.6%
6	Гадаад валютын арилжаа	148	144	(4)	-2.7%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	38	37	(1)	-2.6%
7	Итгэлцэл	43	52	9	20.9%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	13	21	8	61.5%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	37	42	5	13.5%

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 529 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 93.0% нь буюу 492 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 60.7% нь буюу 321 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад

валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 144 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 27.2 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 37 ББСБ нийт ББСБ-уудын 7.0 хувийг бүрдүүлж байна.

Зээл болон гадаад валют арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс харгалзан 3.0 хувь, 2.6 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 61.5 хувиар, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ 28.6 хувиар, итгэлцлийн үйлчилгээ 20.9 хувиар тус тус өссөн байна.

2022 оны I улирлын тайлан мэдээний ирц 97.4% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 529 ББСБ-аас 515 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 11 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 3 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Өмнөх улирлын байдлаар нэгтгэлд хамрагдсан 11 ББСБ-аас 4 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлэх арга хэмжээг Хяналт шалгалт зохицуулалтын газраас авч хэрэгжүүлсэн байна.

## Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах дүрэм журмуудыг шинэчлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар тогтоолоор [“Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”](#)-ыг баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 4 дүгээр 28-ны өдрийн 5807 дугаарт бүртгэн авсан байна.

- Санхүүгийн зохицуулах хорооны [2019 оны 441 дүгээр тогтоол](#) /Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай/-ын 2021 оны хуваарийг цар тахал үүссэн онцгой нөхцөл байдлыг харгалзан 1 жилээр хойшлуулж 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл сунгасан. Энэхүү тогтоолоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа ББСБ-ууд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1.9 тэрбум төгрөгт, Орхон аймаг Баян-Өндөр сум, Дархан-Уул аймгийн Дархан сумд үйл ажиллагаа эрхэлж байгаа ББСБ-ууд 475 сая төгрөгт, гадаад валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-ууд Улаанбаатар хотод 300.0 сая төгрөг, бусад аймаг сумдад 200 сая төгрөгт хүргэх шаардлага үүссэн билээ. Гэвч ББСБ-уудаас материал хүлээн авах хугацааг хойшлуулах хүсэлтүүд ирснийг харгалзан Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлээр материал хүлээн авах хугацааг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд сунгасан байна.

## “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2022 оны I улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 76.9% буюу 407 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 378 ББСБ хэрэгжүүлсэн байна.

## “Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 492 ББСБ-ын 93.5% буюу 460 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

## “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 101 ББСБ, 3,366 удаагийн тохиолдлоор, 395.1 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй,

эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 3 ББСБ, 8 удаагийн тохиолдлоор, 234.3 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

### “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2022 оны I улирлын байдлаар нийт 523 ББСБ-аас 1.3 тэрбум төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 76.2% буюу 396 ББСБ 970.3 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

## Статистик үзүүлэлтүүд

2022 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 21,788 хувь нийлүүлэгчдийн 529 ББСБ, 393 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 4,322 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4,645,134 харилцагч, 1,453,685 зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,645,134	3,688,823	339,219	4,305,915	12,798	4,628,000	17,134	1,216,149	116,412
Үүнээс: Эмэгтэй	2,517,502	1,991,005	178,804	2,338,698	6,017	2,507,098	10,404	628,018	60,255
Эрэгтэй	2,125,076	1,697,017	158,351	1,966,725	6,207	2,118,380	6,696	587,720	55,907
Хуулийн этгээд	2,556	801	2,064	492	574	2,522	34	411	250
Итгэмжлэгчдийн тоо	4,309	4,308	2,639	1,670	-	4,304	5	300	265
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,711	1,629	288	1,423	-	1,708	3	741	178
Зээлдэгчдийн тоо	1,453,685	535,997	297,501	1,156,184	-	1,436,554	17,131	184,801	116,362
Хэвийн	1,362,645	472,307	262,273	1,100,372	-	1,348,189	14,456	151,285	95,984
Хугацаа хэтэрсэн	42,724	29,419	17,704	25,020	-	41,606	1,118	15,870	11,578
Чанаргүй:	48,316	34,271	17,524	30,792	-	46,759	1,557	17,646	8,800
-Хэвийн бус	17,962	13,157	5,479	12,483	-	17,288	674	6,311	2,925
-Эргэлзээтэй	11,698	8,357	3,925	7,773	-	11,559	139	5,306	2,277
- Муу	18,656	12,757	8,120	10,536	-	17,912	744	6,029	3,598
Зээлдэгчдийн насжилт	1,452,144	535,508	296,254	1,155,890	-	1,435,047	17,097	184,588	116,113
18-35 насны	845,491	313,217	164,751	680,740	-	839,067	6,424	119,776	76,764
36-45 насны	356,789	134,543	78,925	277,864	-	350,950	5,839	41,922	23,496
46-55 насны	181,052	67,216	40,903	140,149	-	177,568	3,484	19,328	12,874
55-аас дээш	68,812	20,532	11,675	57,137	-	67,462	1,350	3,562	2,979
Зээлдэгчдийн боловсрол	1,452,144	535,508	296,254	1,155,890	-	1,435,047	17,097	184,588	116,113
-Дээд	861,605	320,376	165,870	695,735	-	853,509	8,096	113,278	73,741
-Тусгай дунд	233,623	61,671	44,889	188,734	-	229,845	3,778	21,303	17,965
-Бүрэн дунд	259,603	109,244	67,986	191,617	-	256,077	3,526	40,344	19,748
-Дунд	86,105	34,316	12,019	74,086	-	84,594	1,511	7,924	4,412
-Бага	11,208	9,901	5,490	5,718	-	11,022	186	1,739	247

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

## Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 33.4 хувиар өсөж давхардсан тоогоор 4,645,134-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өсөж 1,453,685-д хүрлээ.

Нийт харилцагчдын 92.7% буюу 4,305,915 нь, зээлдэгчдийн 79.5% буюу 1,156,184 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 7.3% буюу 339,219, зээлдэгчдийн 20.5% буюу 297,501 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валют арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 12,798 буюу нийт харилцагчдын 0.3 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2018-I	2019-I	2020-I	2021-I	2022-I	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	5,711	7,207	8,104	17,339	21,788	4,449	25.7%
Ажилчдын тоо	2,511	2,820	3,168	3,517	4,322	805	22.9%
Харилцагчдын тоо	1,358,693	1,664,902	2,203,682	3,481,431	4,645,134	1,163,703	33.4%
Зээлдэгчдийн тоо	137,530	263,949	425,859	610,068	1,453,685	843,617	138.3%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.4%	3.4%	3.0%	2.9%	3.1%	+0.2 пункт	

## Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 25.7 хувиар буюу 4,449-өөр өсөж 21,788-д хүрчээ.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	21,788	20,891	2,711	19,077	60	21,592	196	20,756	1,809
Нийт ажилтнуудын тоо	4,322	1,860	2,665	1,657	95	4,097	225	299	431
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	2,530	1,042	1,585	945	51	2,370	160	178	239
Эрэгтэй ажилтны тоо	1,792	818	1,080	712	44	1,727	65	121	192

Нийт хувьцаа эзэмшигчдийн 95.3 хувь буюу 20,756 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,032 буюу 4.7% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 1,809 буюу 8.3% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 196 буюу 0.9% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хөдөө орон нутгийн 85 ББСБ 6 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Одоогоор үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ байхгүй байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>ТЗ-тэй ББСБ-ын тоо</b>	<b>529</b>	<b>52</b>	<b>497</b>	<b>32</b>	<b>37</b>	<b>444</b>	<b>85</b>	<b>4</b>	<b>525</b>	<b>28</b>
1 Зээл	492	52	460	32	-	408	84	4	488	488
2 Факторингийн үйлчилгээ	40	17	27	13	-	40	-	2	38	38
3 Төлбөрийн баталгаа гаргах	27	11	21	6	-	26	1	1	26	26
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	2	1	4	-	5	-	1	4	4
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	38	15	25	13	-	38	-	2	36	36
6 Гадаад валютын арилжаа	144	26	131	13	37	134	10	3	141	141
7 Итгэлцлийн үйлчилгээ	52	52	37	15	-	51	1	4	48	48
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	21	12	15	6	-	20	1	2	19	19
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	42	20	32	10	-	40	2	4	38	38

## Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 83.9% буюу 444 ББСБ, салбаруудын 62.6% буюу 246 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 16.1% буюу 85 ББСБ, салбаруудын 37.4% буюу 147 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2022 оны I улирлын байдлаар 87 ББСБ-ын 393 салбар бүртгэлтэй байна. Нийт салбарын 66.3 хувийг 14 ББСБ-ын 258 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	<b>444</b>	<b>246</b>	<b>690</b>	<b>100.0%</b>
Сүхбаатар дүүрэг	149	35	184	26.7%
Чингэлтэй дүүрэг	126	34	160	23.2%
Баянгол дүүрэг	73	39	112	16.2%
Баянзүрх дүүрэг	50	62	112	16.2%
Хан-Уул дүүрэг	35	27	62	9.0%
Сонгинохайрхан дүүрэг	10	42	52	7.5%
Багануур дүүрэг	1	4	5	0.7%
Налайх дүүрэг	-	3	3	0.4%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Өвөрхангай аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	<b>85</b>	<b>147</b>	<b>232</b>	<b>100%</b>
Архангай аймаг	1	5	6	2.6%
Баян-Өлгий аймаг	4	4	8	3.4%
Баянхонгор аймаг	3	6	9	3.9%
Булган аймаг	1	1	2	0.9%
Говь-Алтай аймаг	1	1	2	0.9%
Говьсүмбэр аймаг	2	3	5	2.2%
Дархан-Уул аймаг	7	14	21	9.1%
Дорноговь аймаг	1	8	9	3.9%
Дорнод аймаг	5	12	17	7.3%
Дундговь аймаг	1	4	5	2.2%
Завхан аймаг	2	3	5	2.2%
Орхон аймаг	9	15	24	10.3%
Өвөрхангай аймаг	10	11	21	9.1%
Өмнөговь аймаг	2	14	16	6.9%
Сүхбаатар аймаг	5	7	12	5.2%
Сэлэнгэ аймаг	5	11	16	6.9%
Төв аймаг	15	3	18	7.8%
Увс аймаг	4	7	11	4.7%
Ховд аймаг	1	4	5	2.2%
Хөвсгөл аймаг	3	7	10	4.3%
Хэнтий аймаг	3	7	10	4.3%

## Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2022 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 3.0 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42.3 хувиар буюу 883.7 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 98.1 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхэнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2021-I дүн	Нийт дүнд эзлэх хувь	2022-I дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	2,007,552.9	96.1%	2,874,556.1	96.7%	867,003.1	43.2%
Мөнгөн хөрөнгө	465,837.6	22.3%	374,225.1	12.6%	-91,612.5	-19.7%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	14,359.2	0.7%	19,793.8	0.7%	5,434.5	37.8%
Зээл (цэврээр)	1,309,635.9	62.7%	2,176,124.1	73.2%	866,488.2	66.2%
Нийт зээл	1,422,016.9	68.1%	2,293,590.4	77.2%	871,573.5	61.3%
(Зээлийн эрсдэлийн сан)	112,381.1	5.4%	117,466.3	4.0%	5,085.3	4.5%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	5,677.8	0.3%	9,019.2	0.3%	3,341.5	58.9%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	14,153.2	0.7%	16,289.9	0.5%	2,136.7	15.1%
Бусад хөрөнгө	197,889.2	9.5%	276,386.7	9.3%	78,497.5	39.7%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)- ийн авлага	-	-	2,715.8	0.1%	2,715.8	-
Эргэлтийн бус хөрөнгө	81,570.4	3.9%	98,286.2	3.3%	16,715.8	20.5%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	103,394.9	4.9%	126,342.3	4.2%	22,947.4	22.2%
(Хуримтлагдсан элэгдэл)	-21,824.5	-1.0%	-28,056.0	-0.9%	-6,231.5	28.6%
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,089,123.3</b>	<b>100.0%</b>	<b>2,972,842.3</b>	<b>100.0%</b>	<b>883,718.9</b>	<b>42.3%</b>

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2018 оны мөн үед 1.0 их наяд төгрөг байсан бол 2022 оны I улирлын байдлаар 2.8 дахин өсөж 3.0 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 2.9 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 87.0% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 237 ББСБ, 7.1% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 98 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 5.9 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 194 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна. Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 1.4 их наяд төгрөг байгаа нь нийт активын 47.8 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	2,136.8	98	71.9%	18.5%	10.0	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	450.2	139	15.1%	26.3%	6.3	2	5.0	1	-	-
1.9-2.5 тэрбум	210.4	98	7.1%	18.5%	-	-	2.2	1	-	-
1.4-1.9 тэрбум	114.4	71	3.8%	13.4%	4.9	3	6.4	4	1.9	1
0.6-1.4 тэрбум	36.9	34	1.2%	6.4%	4.6	5	9.0	10	3.9	4
0.6 тэрбум хүртэлх	24.1	89	0.8%	16.8%	1.3	3	13.4	54	9.5	32
<b>НИЙТ</b>	<b>2,972.8</b>	<b>529</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>27.1</b>	<b>14</b>	<b>36.0</b>	<b>70</b>	<b>15.3</b>	<b>37</b>

## Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 91.6 тэрбум төгрөгөөр буюу 19.7 хувиар буурч 374.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 32.0% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 46.1% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 21.8% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	374.2	104.1	299.6	74.6	14.7	361.7	12.5	24.3	40.0
Бэлэн мөнгө	119.9	2.6	116.5	3.4	12.0	113.4	6.5	0.0	2.8
Харилцах	172.7	56.3	132.4	40.3	2.3	167.7	5.0	17.6	26.3
Хадгаламж	81.7	45.2	50.8	30.9	0.4	80.6	1.1	6.6	10.9

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 38.9%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 4.6%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 81.3% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 2 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



## Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 37.8% буюу 5.4 тэрбум төгрөгөөр өсөж, 2022 оны I улирлын байдлаар 27 ББСБ 19.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Богино хугацаат хөрөнгө оруулалтын 53.0% буюу 10.5 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас, 47.5% буюу 9.4 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 33.7% буюу 6.7 тэрбум төгрөг нь хувьцаа, 65.5% буюу 13.0 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 1.4% буюу 267.2 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
<b>БХХО (ЦЭВРЭЭР)</b>	19,793.8	18,073.3	9,018.5	10,775.2	1.0	19,042.0	751.7	12,096.2	6,052.5
Хувьцаа	6,675.8	5,064.5	2,396.0	4,279.8	1.0	5,924.1	751.7	3,177.2	-
Өрийн бичиг	12,965.4	12,866.2	6,612.5	6,352.8	-	12,965.4	-	8,661.7	6,052.5
Бусад	267.2	257.2	10.0	257.2	-	267.2	-	257.2	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	9,407.9	8,766.8	6,694.5	2,713.5	-	9,406.9	1.0	6,499.6	5,953.4
Арилжааны үнэт цаас	10,500.5	9,421.1	2,324.1	8,176.4	1.0	9,749.8	750.7	5,596.6	99.2

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 21 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 27 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 14 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн

газрын үнэт цаас хэсэгт бүртгэсэн дүн байхгүй байна. Иймээс 13 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн эсхүл санхүүгийн тайланд буруу дансанд бүртгэл хөтөлсөн байна.

### Факторингийн тооцооны авлага

Нийт активын өсөлтийн хамгийн өндөр өсөлтийн хувийг факторингийн тооцооны авлагын цэвэр өсөлт үзүүлсэн байна. Өмнөх оны мөн үеэс 58.9% буюу 3.3 тэрбум төгрөгөөр өсөж 9.0 тэрбум төгрөгт хүрчээ. Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч 2022 оны I улирлын байдлаар 12 ББСБ 592.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 179.5 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 9.0 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ. Факторингийн тусгай зөвшөөрөлтэй 41 ББСБ-уудын 29 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2021-I		2022-I		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	5,722.7	100.0%	9,198.7	100.0%		
Хэвийн	5,554.0	97.1%	8,605.9	93.6%	3,051.9	54.9%
Хугацаа хэтэрсэн	98.1	1.7%	206.4	2.2%	108.3	110.5%
Чанаргүй	70.6	1.2%	386.4	4.2%	315.7	447.0%
Хэвийн бус	36.7	0.6%	127.2	1.4%	90.5	246.9%
Эргэлзээтэй	6.2	0.1%	243.7	2.6%	237.5	3825.6%
Муу	27.8	0.5%	15.5	0.2%	(12.3)	-44.2%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	44.9	0.8%	179.5	2.0%	134.5	299.4%

### Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 2.1 тэрбум төгрөг буюу 15.1 хувиар өсөж 16.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)</b>	16,289.9	6,895.5	11,985.9	4,304.0	15,712.9	577.0	1,077.2	15,212.7	1,898.0
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	18,754.6	7,878.2	14,316.5	4,438.1	18,596.6	158.0	1,888.6	16,866.0	2,468.4
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	5,631.7	2,093.0	5,285.8	345.9	5,627.2	4.5	811.4	4,820.3	1,171.8
Өмчлөх бусад хөрөнгө	3,167.0	1,110.3	2,955.2	211.8	2,743.5	423.5	-	3,167.0	601.4

### Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 61.3% буюу 871.6 тэрбум төгрөгөөр өсөж 2022 оны I улирлын байдлаар 2,293.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 117.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,176.1 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/


	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)</b>	2,176.1	1,150.3	1,389.0	787.1	2,135.1	41.1	290.6	1,885.6	324.9
Нийт зээл	2,293.6	1,200.4	1,481.5	812.1	2,247.5	46.1	300.1	1,993.5	337.4
Хэвийн	2,065.3	1,104.2	1,307.6	757.7	2,025.7	39.6	277.4	1,787.8	311.6
Анхаарал хандуулах	79.3	34.3	56.7	22.6	78.5	0.8	11.3	68.0	9.1
Чанаргүй:	149.0	61.9	117.2	31.8	143.3	5.7	11.4	137.6	16.7
-Хэвийн бус	31.8	12.5	22.2	9.6	31.2	0.6	3.8	28.0	4.1
-Эргэлзээтэй	27.4	11.2	20.6	6.9	27.0	0.4	3.7	23.8	3.6
-Муу	89.8	38.3	74.4	15.3	85.1	4.7	3.9	85.9	9.0
(Зээлийн эрсдэлийн сан)	117.5	50.1	92.6	24.9	112.4	5.0	9.5	107.9	12.5
Нийт зээл (төгрөгийн)	2,217.2	1,137.8	1,428.2	789.0	2,171.4	45.7	271.6	1,945.5	303.9
Нийт зээл (валютын)	76.4	62.6	53.3	23.1	76.0	0.4	28.5	48.0	33.5
Зээлдэгчдийн тоо	1,453,685	535,997	297,501	1,156,184	1,436,554	17,131	184,801	1,268,884	116,362
- Иргэн	1,453,685	535,997	297,501	1,156,184	1,436,554	17,131	184,801	1,163,62	1,342,548
- Хуулийн этгээд	1,541	489	1,247	294	1,507	34	213	249	802

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Тайлант улиралд ББСБ-ууд 1.2 их наяд төгрөгийн зээлийг 3.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 865.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2022 оны I улирлын байдлаар 1,453,685 зээлдэгчийн 2.3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 90.0 хувийг буюу 2.1 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.5 хувийг буюу 79.3 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 6.5 хувийг буюу 149.0 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.


Зураг 3 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.5 пунктээр өссөн бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.7, 3.8 пунктээр тус тус буурсан байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 228.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 51.5%-д буюу 117.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 74.4% буюу 861.4 тэрбум төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 9.5% буюу 110.3 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 74.6% буюу 645.9 тэрбум төгрөг нь бусад ангиллын зээлээс, 9.4% буюу 81.0 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Зураг 4 Зээлийн багцын чанар /хувиар/




Олгосон зээлийн 93.1% буюу 1.1 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 6.9% буюу 79.4 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 93.5% буюу 808.6 тэрбум төгрөг нь иргэдээс, 6.5% нь буюу 56.7 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	6,334.6	0.5%	5,555.3	0.6%	25,045.0	1.1%
2.	Уул уурхай, олборлолт	11,990.6	1.0%	8,409.9	1.0%	55,649.5	2.4%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	10,818.1	0.9%	9,893.4	1.1%	30,910.6	1.3%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	2,718.5	0.2%	688.0	0.1%	4,841.9	0.2%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	638.2	0.1%	703.8	0.1%	2,734.0	0.1%
6.	Барилга	39,903.4	3.4%	28,872.9	3.3%	188,616.9	8.2%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	110,291.9	9.5%	81,008.3	9.4%	291,570.7	12.7%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	32,494.5	2.8%	26,879.4	3.1%	87,482.6	3.8%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	14,800.5	1.3%	7,610.3	0.9%	31,534.3	1.4%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	24,445.7	2.1%	16,226.4	1.9%	90,229.1	3.9%
11.	Мэдээлэл холбоо	2,633.8	0.2%	3,675.3	0.4%	8,114.2	0.4%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	16,791.7	1.4%	12,903.2	1.5%	38,831.9	1.7%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3,953.0	0.3%	3,652.2	0.4%	14,110.1	0.6%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1,027.1	0.1%	780.2	0.1%	5,395.8	0.2%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7,490.1	0.6%	5,617.1	0.6%	18,376.6	0.8%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	758.6	0.1%	449.5	0.1%	1,572.5	0.1%
17.	Боловсрол	5,035.8	0.4%	2,827.4	0.3%	12,179.8	0.5%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	4,717.7	0.4%	3,634.4	0.4%	11,967.5	0.5%
19.	Бусад	861,356.1	74.4%	645,908.5	74.6%	1,374,427.3	59.9%
<i>Иргэнд олгосон зээл</i>		<i>1,078,804.9</i>	<i>93.1%</i>	<i>808,642.0</i>	<i>93.5%</i>	<i>2,020,761.1</i>	<i>88.1%</i>
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		<i>79,395.1</i>	<i>6.9%</i>	<i>56,653.3</i>	<i>6.5%</i>	<i>272,829.3</i>	<i>11.9%</i>
<b>НИЙТ</b>		<b>1,158,200.0</b>	<b>100.0%</b>	<b>865,295.4</b>	<b>100.0%</b>	<b>2,293,590.4</b>	<b>100.0%</b>

Тайлант улиралд олгосон 1.2 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1-2.5 жилийн хугацаатай олгосон зээл нийт зээлийн 26.6 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 18.4 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 5 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Нийт зээлийн ангиллаас харахад 1.2 их наядын зээлийн 69.6 хувийг иргэнд олгосон хэрэглээний зээл, 15.8 хувийг автомашинд зориулсан зээл 5.4 хувийг хуулийн этгээдэд олгосон бизнесийн зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 18 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
<b>Иргэнд олгосон зээл</b>	<b>1,078.8</b>	<b>93.1%</b>	<b>808.6</b>	<b>93.5%</b>	<b>2,020.8</b>	<b>88.1%</b>
Хэрэглээнд зориулсан зээл	805.8	69.6%	607.4	70.2%	1,297.2	56.6%
<i>Үүнээс: Автомашинд зориулсан зээл</i>	<i>182.6</i>	<i>15.8%</i>	<i>115.0</i>	<i>13.3%</i>	<i>492.0</i>	<i>21.5%</i>
Бизнес зориулсан зээл	152.1	13.1%	109.6	12.7%	422.3	18.4%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	39.8	3.4%	29.7	3.4%	151.1	6.6%
Бусад зээл	81.1	7.0%	61.9	7.2%	150.1	6.5%
<b>Хуулийн этгээдэд олгосон зээл</b>	<b>79.4</b>	<b>6.9%</b>	<b>56.7</b>	<b>6.5%</b>	<b>272.8</b>	<b>11.9%</b>
Бизнесийн зээл	62.7	5.4%	47.7	5.5%	217.5	9.5%
Автомашинны зээл	1.4	0.1%	2.0	0.2%	11.5	0.5%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	2.4	0.2%	1.0	0.1%	8.7	0.4%
Бусад зээл	12.9	1.1%	5.9	0.7%	35.1	1.5%
<b>НИЙТ</b>	<b>1,158.2</b>	<b>100.0%</b>	<b>865.3</b>	<b>100.0%</b>	<b>2,293.6</b>	<b>100.0%</b>

## Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2022 оны I улирлын байдлаар 32 ББСБ үзүүлж байна.

Эдгээрийн 8 ББСБ нь зөвхөн аппликэйшн ашиглан зээл олгож байгаа бол 24 ББСБ нь уламжлалт болон финтекийг хослуулан зээл болон бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг санал болгож байна. 2022 оны I улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1,089,752 зээлдэгчийн 354.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 75.0 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 15.5 хувийг бүрдүүлж байна. Нэг зээлдэгчид дунджаар 304.9 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 17.5 дахин бага байна.

Хүснэгт 19 Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд

№	Финтек	App нэр
1	Ашид капитал	Simple
2	Соно финтек	Sono Mongolia
3	Лэндмн	LendMN
4	Нөмөр кредит	numur
5	Омни капитал	Moni Digital
6	Ардкредит	Ard
7	Мобифинанс	Monpay
8	Сэндли	Hi-PayMerchant, Hipay, Sendly
9	Таван богд финанс	PayOn.mn
10	Жи Эс Би Капитал	GSB Prime
11	Централ капитал	kmobi
12	Бизнес-Инвест девелопмент	БИД app
13	Тус финтек	ТУС зээлийн апп
14	Хатан суудал инвест	Zeely
15	Эм Пи Эс Си	Toki
16	Шинэхэн инвест	www.bayan.mn
17	Нэт капитал финанс корпораци	Net app
18	Говьфинанс	CashOne App
19	Зээл Эм Эн платформ	Zeel.mn
20	Очир ундраа ОМЗ	Opay
21	Грийн финтек	t finance
22	Инвескор хэтэвч	Pocket
23	Начин заан финанс	Naizly
24	Нанокапитал	Nano Capital
25	Фин экспресс	Finex
26	Хас хаан	ХАСХААН
27	Монголиа импакт финанс	Qmoni
28	Смарткапитал фонд	My Credit
29	Өсөх ундарга финанс	ufinance
30	Нэмэх төгрөг	Most Money
31	Солонго капитал	100k.mn
32	Грийн-Инвестмент	Gate.mn
<b>Туршилтын шатанд</b>		
33	Би энд жи финанс	Lemond
34	Магна профит энд инвестмент	magna.mn
35	Номинкарт	Omniway
36	Франкфурт капитал	Nar app
37	Гурван зуун жар файнанс	Minu pay
38	Гэрэлфинанс	Gerel
39	Микрокредит	Microcredit
40	Нэйшнл кредит юнион	Tenlend
41	Энт кредит инвестмент	EntcreditMN
<b>Валот арилжаа явуулдаг</b>		
42	Сэнд эм эн	SendMN
43	Би Ар системс	Moex
44	Инвестос	Most Money
45	Файнэншилтрипл групп	WX
<b>Нийт</b>		

## Ногоон зээл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оны 03 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Ногоон санхүүжилт – Бүс нутгийн чуулган”-аар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, “Ногоон хөгжлийн сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх талаар хэлэлцэн, зөвлөмж гаргасан. Зөвлөмжийн 1 дүгээр бүлгийн 1.3-т “Ногоон зээлийг банкны салбарт 10 хувь, ББСБ-уудад 5 хувьд хүргэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ногоон зээлд эрсдэлийн сан байгуулах, хөнгөлөлт урамшуулал олгох, ногоон зээлийн эх үүсвэрийн свопын зардлыг бууруулах зэрэг хөшүүрэг бий болгох” үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хүлээсэн. Үүний дагуу 2022 оны 1 дүгээр улирлаас эхлэн “Монгол Улсын Ногоон таксономи”-ийн үндсэн 8 ангиллын дагуу ББСБ-уудаас “Ногоон зээлийн тайлан”-г авч эхлээд байна.

❖ **Ногоон таксономи** гэдэг нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, тодорхойлолт, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид энэхүү таксономийг ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглана. Ногоон таксономи нь аль нэг салбараар хязгаарлагдахгүй, бизнесийн бүхий л салбарыг хамаарах шалгуур үзүүлэлт юм.

2021 оны жилийн эцсийн байдлаар 21 ББСБ 4,896 зээлдэгчийн 38.8 тэрбум төгрөгийн “**ногоон**” зээлийн үлдэгдэлтэй байсан бол тайлант хугацаанд 17 ББСБ 830 зээлдэгчид 9.9 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.7 хувийн хүүтэйгээр олгож, 18 ББСБ-ын 3,940 зээлдэгчээс 7.0 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 23 ББСБ 5,085 зээлдэгчийн 41.6 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 1.8%-тай тэнцэж байна.


Хүснэгт 20 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 8 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	-	-	-	-	-	-
2. БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	-	-	-	-	249.0	2
3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	-	-	6.5	8	646.1	11
4. НОГООН БАРИЛГА	1,063.9	119	950.9	138	5,003.8	777
5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	6.5	6	0.5	4	153.3	7
6. ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ	10.0	3	1.8	12	217.7	29
7. ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	296.5	9	181.0	11	619.5	14
8. КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	8,490.4	693	5,875.3	3,767	34,753.9	4,245
Үүнээс:						
0-5 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	18.5	1	18.7	3	57.9	6
5-10 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	5,767.1	374	3,100.5	1,969	23,896.2	2,424
10-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээвэр	2,704.8	318	2,756.1	1,795	10,799.8	1,815
<b>НИЙТ</b>	<b>9,867.3</b>	<b>830</b>	<b>7,016.0</b>	<b>3,940</b>	<b>41,643.3</b>	<b>5,085</b>

Ногоон зээлийн үлдэгдлийн 83.5% буюу 34.8 тэрбум төгрөгийг карбон бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн зээлийн үлдэгдэл, бүрдүүлж байна. Сэргээгдэх эрчим хүчний салбарт зээлийн үлдэгдэл байхгүй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 92.1% нь хэвийн, 2.7% нь анхаарал хандуулах, 5.2% нь чанаргүй ангилалд ангилагдсан ба Ногоон барилгын салбарын зээлийн үлдэгдэл хамгийн их буюу 7.6% нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 6 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/



### Бусад хөрөнгө

2022 оны I улирлын байдлаарх 276.4 тэрбум төгрөгийн бусад хөрөнгийн үлдэгдлийн 39.6% буюу 109.6 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 42.8% буюу 118.4 тэрбум төгрөг нь дансны цэвэр авлага, 17.5% буюу 48.4 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 21 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
<b>БУСАД ХӨРӨНГӨ</b>	<b>276,386.7</b>	<b>144,633.2</b>	<b>199,611.3</b>	<b>76,775.3</b>	<b>115.7</b>	<b>270,280.3</b>	<b>6,106.4</b>	<b>37,915.6</b>	<b>30,585.6</b>
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	109,573.4	44,081.1	85,780.9	23,792.4	-	108,157.7	1,415.6	6,895.2	17,142.6
-Үнэт цаасны	491.3	488.1	406.4	84.9	-	88.2	403.2	46.0	3.2
-Зээлийн	106,616.9	41,791.6	84,094.6	22,522.2	-	105,636.7	980.1	6,154.6	16,999.0
-Факторингийн	252.0	207.7	42.0	210.0	-	252.0	-	-	-
-Бусад	2,196.2	1,593.7	1,221.0	975.2	-	2,180.8	15.3	694.6	140.4
Авлага /цэврээр/	118,396.7	78,565.8	82,793.9	35,602.8	6.3	116,189.7	2,207.0	23,627.5	8,848.4
Нийт авлага	121,246.4	80,681.3	84,196.8	37,049.6	6.3	119,031.2	2,215.2	23,899.5	9,727.2
Хэвийн	116,605.8	78,129.3	81,113.8	35,492.0	2.8	114,409.2	2,196.6	23,334.2	8,474.2
Хугацаа хэтэрсэн	621.7	12.6	517.0	104.7	3.5	613.4	8.3	10.1	66.9
Чанаргүй:	4,018.8	2,539.4	2,565.9	1,452.9	-	4,008.6	10.3	555.2	1,186.1
-Хэвийн бус	383.3	355.4	370.8	12.5	-	378.3	5.0	345.6	346.3
-Эргэлзээтэй	110.3	55.1	103.6	6.7	-	110.3	-	49.0	101.7
-Муу	3,525.2	2,128.8	2,091.6	1,433.6	-	3,519.9	5.3	160.6	738.0
Нийт авлага (валютын)	97,887.8	58,762.4	61,674.9	36,212.9	6.3	95,672.6	2,215.2	23,898.3	9,349.8
Нийт авлага (төгрөгийн)	23,358.6	21,918.8	22,521.9	836.7	-	23,358.6	-	1.2	377.4
(Авлагын эрсдэлийн сан)	2,849.7	2,115.5	1,402.9	1,446.8	-	2,841.5	8.2	272.0	878.8
Бусад актив	48,418.1	21,986.3	31,038.0	17,380.1	109.5	45,932.9	2,485.3	7,392.9	4,594.6

### Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2022 оны I улирлын байдлаар 126.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 28.1 тэрбум төгрөгийн элэгдлийг хуримтлуулж бүртгэсэн байна.

Хүснэгт 22 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

<b>ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)</b>	<b>Нийт</b>	<b>Итгэлцэл</b>	<b>Уламжлалт</b>	<b>Финтек</b>	<b>ЗГВА</b>	<b>УБ</b>	<b>ХОН</b>	<b>ХК</b>	<b>ГХО</b>
	<b>98.3</b>	<b>47.3</b>	<b>58.0</b>	<b>40.3</b>	<b>0.4</b>	<b>96.0</b>	<b>2.2</b>	<b>7.6</b>	<b>8.4</b>
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	126.3	60.4	78.0	48.3	0.5	123.1	3.2	10.9	12.3
Барилга байгууламж	46.9	28.7	21.3	25.6	0.1	45.9	1.1	2.4	1.9
Техник хэрэгсэл	43.2	13.7	34.1	9.1	0.1	41.5	1.7	1.9	3.9
Тавилга эд хогшил	14.6	7.3	11.0	3.6	0.1	14.2	0.3	2.8	3.4
Дуусаагүй барилга	6.4	2.5	4.7	1.7	-	6.4	0.0	0.1	0.3
Биет бус хөрөнгө	15.3	8.2	7.0	8.3	0.2	15.2	0.1	3.6	2.8
(Хуримтлагдсан элэгдэл)	28.1	13.1	20.1	8.0	0.1	27.1	1.0	3.3	3.9
Барилга байгууламжийн	5.4	3.5	2.1	3.3	0.0	5.2	0.1	0.9	0.1
Техник хэрэгслийн	16.1	6.1	12.7	3.4	0.0	15.4	0.7	1.0	2.0
Тавилга эд хогшлын	6.6	3.5	5.3	1.3	0.1	6.4	0.2	1.5	1.8

## Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 42.3 хувиар буюу 883.7 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 56.8 хувийг өр төлбөрийн өсөлт, 43.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 23 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2021-I	Нийт дүнд эзлэх хувь	2022-I	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
	дүн		дүн		дүн	хувь
Өр төлбөр	606,950.4	29.1%	1,108,515.4	37.3%	501,565.0	82.6%
Санхүүгийн эх үүсвэр	159,130.9	7.6%	280,353.6	9.4%	121,222.7	76.2%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	162,687.1	7.8%	358,453.4	12.1%	195,766.3	120.3%
Бусад эх үүсвэр	45,461.8	2.2%	57,421.2	1.9%	11,959.5	26.3%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	70,419.1	3.4%	184,504.8	6.2%	114,085.8	162.0%
Төслийн зээлийн санхүүжилт	20,495.0	1.0%	23,938.7	0.8%	3,443.7	16.8%
Бусад өр төлбөр	148,756.5	7.1%	203,843.6	6.9%	55,087.1	37.0%
Эздийн өмч	1,482,172.9	70.9%	1,864,326.9	62.7%	382,154.0	25.8%
Хувьцаат капитал	1,027,321.9	49.2%	1,164,552.9	39.2%	137,231.0	13.4%
Бусад өмч	35,174.4	1.7%	40,000.6	1.3%	4,826.2	13.7%
Сангууд	1,747.0	0.1%	1,226.9	0.0%	(520.1)	-29.8%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	410,093.1	19.6%	587,681.6	19.8%	177,588.5	43.3%
Хоёрдогч өглөг	7,836.6	0.4%	70,865.0	2.4%	63,028.4	804.3%
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>2,089,123.3</b>	<b>100.0%</b>	<b>2,972,842.3</b>	<b>100.0%</b>	<b>883,718.9</b>	<b>42.3%</b>

Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2018 оны мөн үед 811.3 тэрбум төгрөг байсан бол 2022 оны I улирлын байдлаар 2.3 дахин өсөж 1,864.3 тэрбум төгрөгт, өр төлбөрийн хувьд 4.7 дахин өсөж 1.1 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 7 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



### Санхүүгийн эх үүсвэр

2022 оны I улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 76.2% буюу 121.2 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 52 ББСБ-аас 47 ББСБ 4,309 итгэмжлэгчээс 280.4 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 8 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



Улаанбаатар хотын 51 ББСБ 4,304 итгэмжлэгчээс 277.4 тэрбум төгрөг, хөдөө орон нутгийн 1 ББСБ 5 итгэмжлэгчээс 3.0 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 24 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

Итгэлцлийн үйлчилгээний өглөг	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>Итгэлцлийн үйлчилгээний өглөг</b>	<b>280.4</b>	<b>139.9</b>	<b>140.5</b>	<b>277.4</b>	<b>3.0</b>	<b>85.3</b>	<b>195.1</b>	<b>73.6</b>
-Төгрөгөөр	243.5	123.2	120.3	240.5	3.0	68.0	175.5	59.7
-Валютаар	36.8	16.7	20.1	36.8	-	17.3	19.6	13.9
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	52	37	15	51	1	4	48	5
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	47	34	13	46	1	4	43	5
Нийт итгэмжлэгчдийн тоо	4,309	2,639	1,670	4,304	5	300	4,009	265

Хамгийн өндөр дүнгээр буюу 59.2 тэрбум төгрөгийг 157 итгэмжлэгчээс татан төвлөрүүлсэн бол хамгийн олон буюу 1,996 итгэмжлэгчээс 723.7 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

### Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2022 оны I улирлын байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 2.2 дахин өсөж, 100 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 358.5 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 25 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг</b>	<b>358.5</b>		<b>239.1</b>	<b>205.8</b>	<b>152.7</b>	<b>356.2</b>	<b>2.3</b>	<b>69.8</b>	<b>288.7</b>	<b>82.0</b>
Хугацаагаар:										
Богино хугацааг зээл	143.1	39.9%	104.2	87.7	55.4	142.4	0.6	24.7	118.3	25.3
Урт хугацааг зээл	215.4	60.1%	134.9	118.1	97.3	213.8	1.6	45.1	170.3	56.7
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	272.1	75.9%	183.6	146.9	125.2	269.8	2.3	49.8	222.3	48.7
Валютаар	86.4	24.1%	55.5	58.9	27.5	86.4	-	20.0	66.3	33.4
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	280.2	78.2%	187.5	153.8	126.4	277.9	2.3	53.3	226.9	52.2
Зээл /төгрөгөөр/	272.1	75.9%	183.6	146.9	125.2	269.8	2.3	49.8	222.3	48.7
Зээл /валютаар/	8.1	2.3%	3.8	6.9	1.2	8.1	-	3.5	4.5	3.5
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	78.3	21.8%	51.6	52.0	26.3	78.3	-	16.5	61.8	29.8

### Бусад эх үүсвэр

Хүснэгт 26 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХК	ХХК	ГХО
<b>Нийт</b>	<b>57,421.2</b>	<b>100.0%</b>	<b>43,967.6</b>	<b>8,176.4</b>	<b>49,244.9</b>	<b>57,421.2</b>	<b>214.2</b>	<b>57,207.1</b>	<b>1,206.7</b>
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр	51.0	0.1%	51.0	-	51.0	51.0	-	51.0	-

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	16,370.5	28.5%	9,316.1	6,569.6	9,800.9	16,370.5	214.2	16,156.3	1,206.7
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	161.5	0.3%	161.5	-	161.5	161.5	-	161.5	-
Факторингийн үйлчилгээний өглөг	40,671.4	70.8%	34,272.3	1,606.7	39,064.8	40,671.4	-	40,671.4	-
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	166.8	0.3%	166.7	0.1	166.7	166.8	-	166.8	-

2022 оны I улирлын байдлаар 16 ББСБ 57.4 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Нэр бүхий 8 ББСБ 16.4 тэрбум төгрөгийн Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 7 ББСБ 40.7 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй гарчээ.

*Зураг 9 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /сая төгрөгөөр/*

Бусад эх үүсвэр	2017-I	2018-I	2019-I	2020-I	2021-I
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр	-	-	-	-	51.0
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	6,557.6	2,545.1	6,179.0	3,753.5	16,370.5
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	3,046.2	3,694.6	1,173.3	5,709.1	161.5
Факторингийн үйлчилгээний өглөг	-	8,134.2	5,904.2	35,999.1	40,671.4
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	-	166,772.50
<b>Нийт</b>	<b>9,603.8</b>	<b>14,373.9</b>	<b>13,256.4</b>	<b>45,461.8</b>	<b>57,421.2</b>

Өмнөх оны мөн үеэс мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 39.3 хувиар буурсан бол төлбөр тооцооны үйлчилгээний өглөг болон факторингийн үйлчилгээний өглөг харгалзан 4.9, 6.1 дахин өссөн байна.

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.


### ББСБ-аас гаргасан өрийн бичиг

2022 оны I улирлын байдлаар 41 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 1,711 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 184.5 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 27 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/*

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	<b>184,504.8</b>	<b>116,248.1</b>	<b>69,218.8</b>	<b>115,286.0</b>	<b>184,491.6</b>	<b>13.2</b>	<b>42,128.0</b>	<b>142,376.8</b>	<b>29,457.0</b>
Төгрөгөөр	171,372.9	108,241.1	64,093.9	107,279.1	171,359.7	13.2	42,128.0	129,244.9	29,457.0
Валютаар	13,131.9	8,007.0	5,124.9	8,007.0	13,131.9	-	-	13,131.9	-

*Зураг 10 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/*



Өрийн бичгийн үлдэгдэл 2017 оны мөн үеэс 46.5 дахин өсөж 184.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 27.3% байсан бол 2022 оны I улирлын 20.2 пунктээр буурч 7.1%-д хүрсэн байна.

Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэгдээгүй, 2022 оны эхний улирлын байдлаар санхүүгийн тайланд өрийн бичгийн үлдэгдэлтэй 19 ББСБ байгаа тул эдгээр ББСБ-уудын журмын үйлчлэх хугацаанд өрийн бичиг шинээр болон нэмж гаргасан эсэхэд хяналт тавих шаардлагатай байна.

## Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 18 ББСБ 23.9 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 28 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн 23,938.7	Нийт дүнд ЭЗЛЭХ ХУВЬ	Итгэлцэл 19,552.6	Уламжлалт 13,018.7	Финтек 10,920.0	УБ 21,422.7	ХОН 2,516.0	ХК -	ХХК 23,938.7	ГХО 7,582.4
<b>Хугацаагаар</b>										
Богино хугацаат	1,431.6	6.0%	550.0	1,431.6	-	1,262.6	169.0	-	1,431.6	-
Урт хугацаат	22,507.2	94.0%	19,002.6	11,587.2	10,920.0	20,160.2	2,347.0	-	22,507.2	7,582.4
<b>Төрлөөр</b>										
Засгийн газрын	-	-	-	-	-	-	-	-	-	-
Гадаадын	8,004.8	33.4%	7,502.4	8,004.8	-	8,004.8	-	-	8,004.8	7,502.4
Дотоодын	9,711.5	40.6%	6,085.0	3,791.5	5,920.0	7,427.5	2,284.0	-	9,711.5	80.0
Бусад	6,222.5	26.0%	5,965.2	1,222.5	5,000.0	5,990.5	232.0	-	6,222.5	-
<b>Валютын төрлөөр</b>										
Төгрөгөөр	20,797.9	86.9%	16,411.8	9,877.9	10,920.0	18,281.9	2,516.0	-	20,797.9	4,441.6
Валютаар	3,140.8	13.1%	3,140.8	3,140.8	-	3,140.8	-	-	3,140.8	3,140.8

## Бусад өр төлбөр

2022 оны I улирлын байдлаар 487 ББСБ 203.8 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 15.9% буюу 32.3 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, 82.9% буюу 168.9 тэрбум төгрөг нь бусад пассив, 1.3% буюу 2.6 тэрбум төгрөг нь санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн өглөгийн үлдэгдэл байна.

Хүснэгт 29 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн 203,843.6	Итгэлцэл 131,287.0	Уламжлалт 138,244.8	Финтек 65,598.8	ЗГВА 285.9	УБ 201,023.5	ХОН 2,820.1	ХК 50,746.6	ХХК 153,096.9	ГХО 44,125.7
<b>Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг</b>										
Ангиллаар										
Зээлийн	15,001.0	5,803.4	8,037.6	6,963.4	-	14,983.3	17.7	1,816.8	13,184.2	1,645.5
Үнэт цаасны	2,874.7	2,623.2	678.4	2,196.3	-	2,874.7	-	946.8	1,927.9	663.0
Бусад	14,447.9	11,987.0	5,023.2	9,424.7	-	14,447.4	0.5	4,404.7	10,043.2	3,177.1
<b>Валютын төрлөөр</b>										
Төгрөгөөр	29,808.3	18,404.5	12,412.6	17,395.7	-	29,790.1	18.2	6,701.7	23,106.5	5,011.6
Валютаар	2,515.3	2,009.1	1,326.6	1,188.8	-	2,515.3	-	466.6	2,048.7	474.0
<b>Бусад пассив</b>	<b>168,941.9</b>	<b>108,295.4</b>	<b>124,505.7</b>	<b>44,436.3</b>	<b>285.9</b>	<b>166,140.0</b>	<b>2,801.9</b>	<b>43,578.2</b>	<b>125,363.7</b>	<b>38,640.2</b>
<b>Деривативийн өглөг</b>	<b>2,578.0</b>	<b>2,578.0</b>	<b>-</b>	<b>2,578.0</b>	<b>-</b>	<b>2,578.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2,578.0</b>	<b>-</b>

## Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.4% буюу 137.2 тэрбум төгрөгөөр өсөж 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь нийт пассивын 39.2 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 30 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/


Хувьцаат капитал	Дүн 1,164,552.9	Итгэлцэл 258,409.6	Уламжлалт 959,002.6	Финтек 205,550.3	ЗГВА 13,901.9	УБ 1,122,508.2	ХОН 42,044.7	ХК 27,342.6	ХХК 1,137,210.3	ГХО 95,656.1
Энгийн хувьцаа	1,166,351.1	260,927.5	958,463.3	207,887.8	13,901.9	1,124,348.7	42,002.4	29,683.7	1,136,667.4	95,538.7
Давуу эрхтэй хувьцаа	749.7	30.0	749.7	-	-	707.4	42.3	-	749.7	121.0
Халаасны хувьцаа	2,548.0	2,548.0	210.4	2,337.5	-	2,548.0	-	2,341.1	206.8	3.6

Хувьцаат капиталын хэмжээ 2016 оны мөн үеэс 1.8 дахин өсөж 1.2 их наяд төгрөгт, Үүнээс энгийн хувьцаа 1.8 дахин өсөж 1.2 их наяд төгрөгт, давуу эрхийн хувьцаа 37.6 хувиар буурч 749.7 сая төгрөгт, халаасны хувьцаа 12.3 дахин өсөж 2.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2022 оны I улирлын байдлаар 529 ББСБ-ын 1.2 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 5 ББСБ-ын 749.7 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 3 ББСБ-ын 2.5 тэрбум төгрөгийн

халаасны хувьцаа бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад халаасны хувьцааны дүн 1.5 дахин буюу 833.2 сая төгрөгөөр өссөн байна.

Зураг 11 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 287 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 80.9% буюу 942.7 тэрбум төгрөг байна. Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 242 ББСБ-ын 221.9 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 19.1 хувийг бүрдүүлж байна. Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 207.2 тэрбум төгрөг байгаа нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 17.8 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 31 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	293.0	27	25.2%	5.1%	5.6	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	427.7	148	36.7%	28.0%	2.5	1	3.7	1	-	-
1.9-2.5 тэрбум	222.0	112	19.1%	21.2%	-	-	-	-	-	-
1.4-1.9 тэрбум	183.8	128	15.8%	24.2%	2.8	2	2.8	2	1.4	1
0.6-1.4 тэрбум	15.9	19	1.4%	3.6%	4.5	6	6.7	8	3.7	4
0.6 тэрбум хүртэлх	22.2	95	1.9%	18.0%	1.6	4	11.8	59	8.8	32
<b>НИЙТ</b>	<b>1,164.6</b>	<b>529</b>	<b>100.0%</b>	<b>100.0%</b>	<b>17.0</b>	<b>14</b>	<b>25.0</b>	<b>70</b>	<b>13.9</b>	<b>37</b>

### Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар өсөж 40.0 тэрбум төгрөгт, сангууд 29.8 хувиар буурч 1.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 32 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/


	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
<b>Бусад өмч</b>	<b>40,000.6</b>	<b>33,549.2</b>	<b>24,781.3</b>	<b>15,219.2</b>	<b>257.9</b>	<b>39,646.0</b>	<b>354.6</b>	<b>31,397.1</b>	<b>8,603.5</b>	<b>18,582.4</b>
Нэмж төлөгдсөн капитал	29,746.8	26,451.5	21,646.6	8,100.2	228.1	29,561.8	185.0	25,771.4	3,975.4	18,577.5
Дахин үнэлгээний нэмэгдэл	8,083.9	6,356.3	1,735.4	6,348.5	-	8,048.6	35.3	5,568.3	2,515.6	4.9
Хандивын капитал	2,169.8	741.3	1,399.2	770.6	29.7	2,035.6	134.2	57.3	2,112.5	-
<b>Сангууд</b>	<b>1,226.9</b>	<b>183.8</b>	<b>1,221.9</b>	<b>5.0</b>	<b>-</b>	<b>451.1</b>	<b>775.8</b>	<b>-</b>	<b>1,226.9</b>	<b>18.4</b>
Нөөцийн сан	732.0	176.6	732.0	-	-	197.9	534.1	-	732.0	14.9
Нийгмийн хөгжлийн сан	494.9	7.3	489.9	5.0	-	253.2	241.7	-	494.9	3.5

### Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 43.3% буюу 177.6 тэрбум төгрөгөөр өсөж 587.7 тэрбум төгрөгт хүрчээ.

Тайланд улиралд 420 ББСБ 81.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 12 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 97 ББСБ 2.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 33 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/




### Хоёрдогч өглөг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хоёрдогч өглөгийн хэмжээ 9.0 дахин өсөж 70.1 тэрбум төгрөгт хүрчээ. Энэхүү өсөлтийн 95.1 хувийг шинээр хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татсан 4 ББСБ-ын 59.2 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн өсөлт бүрдүүлж байна. 2022 оны I улирлын байдлаар 9 ББСБ 70.2 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.

## Ашигт ажиллагаа

2022 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 184.4 тэрбум төгрөгийн орлого олж, 105.8 тэрбум төгрөгийн зардал гаргаж 78.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 69.0% буюу 75.3 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 56.5% буюу 38.2 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 89.2% буюу 37.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 12 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд хүүгийн орлого 72.8% буюу 61.3 тэрбум төгрөгөөр өсжээ. Цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-уудын ашигт ажиллагаанд төдийлөн өсөлт байхгүй байсан бол энэ оны эхний улирлын байдлаар ББСБ-уудын үндсэн үйл ажиллагаа болох зээл олголт нэмэгдэж, үүнийгээ дагаад хүүгийн орлого болон үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого харгалзан 72.8% болон 91.7 хувиар тус тус нэмэгдсэн байна. /Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлогын дийлэнх хувийг бага дүнтэй, богино хугацаатай, хүүгүй онлайн зээл олгож буй ББСБ-уудын үйлчилгээний шимтгэлийн дүн бүрдүүлж байна./

Хүснэгт 34 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/

ОРЛОГО	2021-I	2022-I	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	84,247.0	145,573.4	79.0%	61,326.5	72.8%
Хүүгийн бус орлого	20,953.3	32,384.7	17.6%	11,431.4	54.6%
-Санхүүгийн үйлчилгээний орлого	14,846.2	22,206.0	12.0%	7,359.8	49.6%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	3.2	1.4	0.0%	(1.8)	-57.3%
- Мөнгөн гүйвүүдлын орлого	667.2	530.6	0.3%	(136.6)	-20.5%
- Картын үйлчилгээний орлого	-	-	-	-	-
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	133.7	25.2	0.0%	(108.5)	-81.2%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	8,643.2	16,565.7	9.0%	7,922.6	91.7%
- Бусад	5,399.0	5,083.1	2.8%	(315.9)	-5.9%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	3,864.1	6,254.6	3.4%	2,390.4	61.9%
Ердийн бус орлого	64.3	172.1	0.1%	107.8	167.6%
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>109,128.7</b>	<b>184,384.8</b>	<b>100.0%</b>	<b>75,256.1</b>	<b>69.0%</b>
<b>ЗАРДАЛ</b>					
Хүүгийн зардал	8,432.9	19,522.7	18.5%	11,089.9	131.5%
Хүүгийн бус зардал	41,151.1	66,649.4	63.0%	25,498.2	62.0%
Болзошгүй эрсдэлийн зардал	13,492.9	12,164.4	11.5%	(1,328.6)	-9.8%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	725.3	1,473.2	1.4%	747.9	103.1%
Орлогын албан татварын зардал	3,743.2	5,937.0	5.6%	2,193.8	58.6%
Ердийн бус зардал	42.1	22.7	-	(19.4)	-46.2%
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>67,587.6</b>	<b>105,769.3</b>	<b>100.0%</b>	<b>38,181.8</b>	<b>56.5%</b>
<b>АШИГ</b>					
<b>ЦЭВЭР АШИГ</b>	<b>41,541.1</b>	<b>78,615.5</b>	<b>100.0%</b>	<b>37,074.3</b>	<b>89.2%</b>

Ердийн бус орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өсөж 172.1 сая төгрөгт хүрсэн ба энэ нь 2020 оноос эхлэн дагаж мөрдөж байгаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т “Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогыг 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй байхаар жилийн эцсийн

татварын тайланд тусгасан, доор дурдсанаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, энэ хуулийн 20.2.7-д зааснаас бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлнө” гэж заасны дагуу хөнгөлөлт эдэлсэн ББСБ-уудын орлогын өсөлттэй холбоотой.


Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь хүүгийн бус зардал болон болзошгүй эрсдэлийн зардал байна. Хүүгийн бус зардал болон болзошгүй эрсдэлийн зардал харгалзан 62.0% буюу 25.5 тэрбум төгрөгөөр, 103.1% буюу 747.9 сая төгрөгөөр өсжээ. Болзошгүй эрсдэлийн зардлын өсөлтийн 88.5 хувийг зээлийн эрсдэлийн зардлын өсөлт бүрдүүлж байна.

Хүснэгт 35 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хүүгийн орлого	145,573.4	77,044.5	85,301.8	60,271.6	4.8	142,840.3	2,733.2	14,572.8	18,076.9
Хүүгийн бус орлого	32,384.7	22,055.4	15,751.3	16,633.4	374.5	32,044.7	340.1	8,199.6	4,445.6
- Санхүүгийн үйлчилгээний орлого	22,206.0	16,535.9	9,229.6	12,976.4	-	21,872.1	333.9	8,009.3	3,701.7
Итгэлцлийн үйлчилгээний орлого	1.4	1.4	-	1.4	-	1.4	-	-	-
Мөнгөн гуйвуулгын орлого	530.6	81.6	461.7	68.9	-	530.6	-	3.3	-
Картын үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-	-	-	-
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	25.2	25.2	-	25.2	-	25.2	-	25.2	-
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	16,565.7	14,154.9	5,398.4	11,167.3	-	16,365.4	200.3	7,568.1	3,506.1
Бусад	5,083.1	2,272.8	3,369.5	1,713.6	-	4,949.5	133.6	412.7	195.5
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6,254.6	1,880.1	5,886.7	367.9	18.3	5,959.1	295.5	416.0	571.8
Ердийн бус орлого	172.1	-	172.0	0.0	-	163.6	8.4	-	-
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>184,384.8</b>	<b>100,980.0</b>	<b>107,111.8</b>	<b>77,273.0</b>	<b>397.6</b>	<b>181,007.6</b>	<b>3,377.2</b>	<b>23,188.4</b>	<b>23,094.3</b>
<b>ЗАРДАЛ</b>									
Хүүгийн зардал	19,522.7	12,077.6	9,312.7	10,210.0	-	19,424.1	98.6	3,338.9	2,911.9
Хүүгийн бус зардал	66,649.4	38,307.9	34,416.9	32,232.5	325.0	65,485.5	1,163.9	9,961.3	9,771.2
Болзошгүй эрсдэлийн зардал	12,164.4	5,549.1	7,581.5	4,582.8	-	11,987.3	177.1	2,162.2	2,131.8
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,473.2	802.9	748.0	725.2	0.6	1,452.3	20.9	117.2	138.2
Орлогын албан татварын зардал	5,937.0	2,948.7	4,239.1	1,697.9	1.3	5,812.0	125.0	887.1	954.5
Ердийн бус зардал	22.7	5.0	22.7	-	-	22.4	0.2	-	-
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>105,769.3</b>	<b>59,691.1</b>	<b>56,320.9</b>	<b>49,448.4</b>	<b>326.9</b>	<b>104,183.6</b>	<b>1,585.7</b>	<b>16,466.7</b>	<b>15,907.6</b>
<b>АШИГ</b>									
<b>ЦЭВЭР ОРЛОГО</b>	<b>78,615.5</b>	<b>41,288.8</b>	<b>50,790.9</b>	<b>27,824.6</b>	<b>70.8</b>	<b>76,824.0</b>	<b>1,791.5</b>	<b>6,721.7</b>	<b>7,186.8</b>

Гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 144 ББСБ-аас тайлант улиралд ирүүлсэн мэдээгээр 453.6 тэрбум төгрөгийн валют худалдан авч, 487.9 тэрбум төгрөгийн валют зарсан байна.

Хүснэгт 36 2022 оны I улирлын валют арилжааны сарын мэдээ /тэрбум төгрөгөөр/



## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2022 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 529 ББСБ-ын 84.1% буюу 445 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 15.9% нь буюу 74 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 68 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 5 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 3 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 6 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 37 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /52 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /440 ББСБ/		ЗГВА /37 ББСБ/		Нийт /529 ББСБ/		
		√	X	√	X	√	X	√	X	
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	52	-	436	4	37	-	525	4	
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	52	-	436	4	37	-	525	4	
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	52	-	437	3	37	-	526	3	
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	49	3	432	8	37	-	518	11	
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу )	49	3	410	30	36	1	506	495	
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	52	-	430	10	XXX		524	519	
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	52	-	440	-				530	529
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	51	1	439	1				529	527
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	50	2	437	3				527	524
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	52	-	440	-				530	529
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	52	-	440	-				530	529
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “П” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	52	-	440	-				530	529
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	52	-	440	-				530	529
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	52	-	439	1				528	528
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	49	3	430	10				516	13
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	52	-		XXX				530	-
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	52	-	439	1				530	528
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	50	2	428	12		36	1	514	15

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо  
X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 34 ББСБ дутуу байгуулсан бол үндсэн хөрөнгийн зохистой харьцааг хамгийн олон буюу 15 ББСБ хангаагүй, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 13 ББСБ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 11 ББСБ тус тус хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 11 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай байна.

## Дүгнэлт

2022 оны I улирлын байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 529 ББСБ-аас 515 ББСБ тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан нэр бүхий 11 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 3 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2021 оны I улирлын байдлаар давхардсан тоогоор 21,788 хувь нийлүүлэгчдийн 529 ББСБ, 393 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 4,322 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4,645,134 харилцагч, 1,453,685 зээлдэгчид хүрч үйлчилж байна.

ББСБ-уудын нэгтгэлийн танилцуулгыг боловсруулах явцад бусдаас итгэлцэл болон өрийн бичиг хэлбэрээр эх үүсвэр татсан ББСБ-уудын тухайн үйлчилгээний харилцагчдын тоо нь статистик мэдээлэл болон тухайн тайлангийн дэлгэрэнгүй хэсэгт бөглөсөн тоо мэдээнээс зөрөх, тусгай зөвшөөрөлгүй, тухайн үйлчилгээний үлдэгдэлгүй ББСБ-ууд холбогдох харилцагчдын тоог нөхөх, аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд “Зээл олголт эргэн төлөлт, зээлийн хүүгийн судалгааны тайлан”-г дутуу нөхсөнөөс үүдэн мэдээллийг дахин тодруулах шаардлага үүсэж байна. Мөн шинээр авч байгаа тоо мэдээг нөхсөн байдал тун хангалтгүй байсан тул тухайн тайлангуудын нэгтгэлийг танилцуулгад дурдаагүй болно.

### Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 42.3 хувиар өсөж, банкны салбарын 7.4%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 75.2%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үеүдтэй харьцуулахад 50 пунктээр буурсан дүн юм. Энэ нь ББСБ-уудын бусдаас татан төвлөрүүлж буй эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэж байгааг харуулж байна. 2022 оны I улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 42.3 хувиар буюу 883.7 тэрбум төгрөгөөр өсөж 3.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 98.1 хувийг цэвэр зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 56.8 хувийг өр төлбөрийн өсөлт, 43.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 1.4 их наяд төгрөг байгаа нь нийт активын 47.8 хувийг бүрдүүлж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 207.2 тэрбум төгрөг байгаа нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 17.8 хувийг бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн 2 жилийн хугацаанд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /142 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна. Мөн дотоод, гадаад банк санхүүгийн байгууллагаас авсан зээл дансанд хувь хүн, санхүүгийн бус хуулийн этгээдээс эх үүсвэр татан төвлөрүүлж байгаа ББСБ-ууд нь эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлж байгааг анхаарах шаардлагатай байна.

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 21 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 27 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 14 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна. Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт бүртгэсэн дүн байхгүй байна. Иймээс 14 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн эсхүл санхүүгийн тайланд буруу дансанд бүртгэл хөтөлсөн байна. Эдгээрээс 4 ББСБ богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүй эрхэлсэн тул холбогдох арга хэмжээг авч, хууль журмын хэрэгжилтийг хангуулж ажиллах нь зүйтэй.

Тайлант улиралд ББСБ-ууд 1.2 их наяд төгрөгийн зээлийг 3.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 865.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2022 оны I улирлын байдлаар 1,453,685 зээлдэгчийн 2.3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.5 пунктээр өссөн бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.7, 3.8 пунктээр тус тус буурсан байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 228.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 51.5%-д буюу 117.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Тайлант хугацаанд салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 42.3 хувиар буюу 883.7 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 56.8 хувийг өр төлбөрийн өсөлт, 43.2 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. ББСБ-ын салбар нь 2022 оны I улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг 1.8 дахин, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 2.2 дахин, ББСБ-аас гаргасан өрийн бичгийн үлдэгдэл 2.6 дахин өссөн байгаа нь ББСБ-уудын хувьд бусдаас өртөг бүхий эх үүсвэрийг татан төвлөрүүлж байгааг харуулж байна. Мөн хоёрдогч өглөгийн хэмжээ 9.0 дахин өсөж 70.9 тэрбум төгрөгт хүрчээ.

### Ашигт ажиллагаа

2022 оны I улирлын байдлаар ББСБ-ууд 184.4 тэрбум төгрөгийн орлого олж, 105.8 тэрбум төгрөгийн зардал гаргаж 78.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 69.0% буюу 75.3 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 56.5% буюу 38.2 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 89.2% буюу 37.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Цар тахлын улмаас сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-уудын үндсэн үйлчилгээ болох зээлийн хүүгийн орлогыг хойшлуулсны улмаас салбарын орлого хумигдаж ашигт ажиллагаанд төдийлөн өсөлт байхгүй байсан бол энэ оны эхний улирлын байдлаар ББСБ-уудын үндсэн үйл ажиллагаа болох зээл олголт нэмэгдэж, үүнийг дагаад хүүгийн орлого болон үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого харгалзан 72.8% болон 91.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.

### Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2021 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 529 ББСБ-ын 84.1% буюу 445 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан бол нийт ББСБ-уудын 15.9% нь буюу 74 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Алдагдсан зохистой харьцааны үзүүлэлтээс хөрөнгийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 34 ББСБ дутуу байгуулсан бол үндсэн хөрөнгийн зохистой харьцааг хамгийн олон буюу 15 ББСБ хангаагүй, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 13 ББСБ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 11 ББСБ тус тус хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 11 ББСБ-ыг хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай байна.

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР